



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2024 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 4/02

Улаанбаатар хот

Сонгуулийн хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1, Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.2 дахь хэсгийг тус тус үндэслэн нийслэлийн Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит XXIII хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн 1 дүгээр хэсгийг дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрээр тогтоож, хэсгийн төвийг Биеийн тамир, спортын хорооны байранд, 2 дугаар хэсгийг дүүргийн 2 дугаар хорооны нутаг дэвсгэрээр тогтоож, хэсгийн төвийг “Хангай” цогцолбор сургуулийн хичээлийн хоёрдугаар байранд байхаар тус тус тогтоосугай.

2. Тогтоолыг хуулийн хугацаанд Сонгуулийн Ерөнхий хороо, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэст тус тус хүргүүлэхийг Хурлын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга (М.Давааням)-д даалгасугай.

ДАРГА

Ф.МӨНХГЭРЭЛ



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ